



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 26 өдөр

Дугаар 41/532

Чөлгис хот

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, 30 дугаар зүйлийн 30.1.5 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Газрын кадастрын мэдээллийн сан"-г солбицлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх ажлын хүрээнд "Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах, геодезийн солбицол, өндөр тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх" ажил хэрэгжсэнтэй холбогдуулан "Монгол эмимпекс концерн" ХХК-д 1988м<sup>2</sup> газрыг 37 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.


2. "Монгол эмимпекс концерн" ХХК-ий эзэмшил газрын хэмжээ байршлыг хавсралтаар баталсугай.

3. Газар эзэмших эрхийн гэрчилгээг олгон гэрээ байгуулж, гэрээний биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Д.Баярхүү/-т үүрэг болгосугай.

4. Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин, гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг "Монгол эмимпекс концерн" ХХК-ий захиралд үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 1997 оны 04 дүгээр захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231011111